

“ЗАМЫН-ҮҮД” ЧӨЛӨӨТ БҮСИЙН 2024 ОНЫ ЖИЛИЙН ЭЦСИЙН ГҮЙЦЭТГЭЛИЙН ТАЙЛАН

Д/д	Стратеги төлөвлөгөө болон үндэслэж байгаа бусад бодлогын баримт бичиг, хууль тогтоомж	Төсөв	Шалгуур үзүүлэлт	Суурь түвшин	Зорилтот түвшин	Хүрсэн түвшин буюу хэрэгжилт /хүрээгүй бол тайлбар/	Гүйцэтгэлийн хувь	
							Байгууллагын үнэлгээ	ШСАА-ны үнэлгээ
Нэг. Бодлогын баримт бичигт тусгагдсан зорилт, арга хэмжээ								
Чөлөөт бүсүүдийн дэд бүтцийн бүтээн байгуулалтын ажлыг үе шаттайгаар хийж, экспорт болон дотоодын зах зээлд чиглэсэн худалдаа, үйлчилгээ, хөнгөн үйлдвэрлэлийг хөгжүүлэх нөхцөлийг бүрдүүлж, гадаад, дотоодын хөрөнгө оруулагчдыг дэмжиж ажиллах зорилт								
1.1.1	“Замын-Үүд” чөлөөт бүсэд гадаад, дотоодын хөрөнгө оруулалт татах, чөлөөт бүсийн үйл ажиллагааг сурталчлах, арга хэмжээг зохион байгуулах;	Урсгал зардлаас	Арга хэмжээ, тоо	Арга хэмжээний тоо-4	Арга хэмжээний тоо-8	- БНХАУ-ын ӨМӨЗО-ны Эрээн хотын Ардын засгийн газартай хамтран Бээжин хотноо 2024 оны 05 дугаар сарын 31-ний өдөр, Шанхай хотноо 2024 оны 11 дүгээр сарын 07-ны өдөр Монгол, Хятадын “Замын-Үүд, Эрээний эдийн засгийн хамтын ажиллагааны бүс”-ийн хөрөнгө оруулалтыг дэмжих хоёр удаагийн чуулга уулзалтыг зохион байгуулж, БНХАУ-ын талаас 450, Монгол Улсын талаас 130 аж ахуйн нэгж, бизнес эрхлэгч, хөрөнгө оруулагчид оролцов. 2024 оны 10 дугаар сарын 28-ны өдөр зохион байгуулагдсан Монгол-Казахстаны хамтарсан бизнес зөвлөлийн анхдугаар хуралд Замын-Үүд, Эрээний Эдийн засгийн хамтын ажиллагааны бүсийн танилцуулгыг хийж, Бүгд Найрамдах Казахстан Улсын Хоргос чөлөөт бүстэй Хамтын ажиллагааны санамж бичгийг үзэглэв. 2024 оны 10 дугаар сарын 26-ны өдөр зохион байгуулагдсан Бүсүүдийн хөгжлийн үндэсний чуулганы Говийн бүсийн Хамтын ажиллагаа салбар хэлэлцүүлэгт “Замын-Үүд” чөлөөт бүсээс панелистаар оролцсон. - ОХУ, БНХАУ-аас Монгол Улсад суугаа Элчин Сайд, АНУ-аас Монгол Улсад суугаа Элчин сайдын яамны төлөөлөл,	100%	

						Монгол Улсаас БНХАУ-д суугаа Элчин Сайд, Монгол Улсын Гадаад харилцааны яамны төлөөллийг хүлээн авч Замын-Үүд чөлөөт бүсийн хөрөнгө оруулалт, бүтээн байгуулалт, үйл ажиллагааны талаар танилцуулга хийж, Эдийн засгийн хамтын ажиллагааны бүс"-ийн хөрөнгө оруулалтын талаар санал солилцов.		
1.1.2	Хамтын ажиллагааны бүсийн ерөнхий төлөвлөгөөтэй уялдуулж “Замын-Үүд” чөлөөт бүсэд хөрөнгө оруулалт татах, маркетинг, бизнес хөгжүүлэх стратеги төлөвлөгөө боловсруулж дээд шатны байгууллагад танилцуулах;	Урсгал зардлаас	Гүйцэтгэл, хувиар	-	70%	- Эдийн засгийн хамтын ажиллагааны бүс хөгжүүлэх төслийн менежментийн зөвлөх үйлчилгээний багтай багтай хамтран Замын-Үүд чөлөөт бүсийн хөрөнгө оруулалт, маркетинг, бизнес хөгжүүлэх стратеги төлөвлөгөөг боловсруулах ажлыг хэрэгжүүлж, “Явцын тайлан” 1, 2, 3 дугаарт дүн шинжилгээ хийж, санал боловсруулан Шадар Сайдын ажлын албанд хүргүүлж ажиллав. - Менежментийн зөвлөх үйлчилгээний багаас 2025 оны 09 дүгээр сард “Замын-Үүд” чөлөөт бүсэд хөрөнгө оруулалт татах, маркетинг, бизнес хөгжүүлэх стратеги төлөвлөгөөг хүлээлгэн өгөх ажлын хуваарьтай тул энэ ажил үргэлжлэн хэрэгжих юм.	75,1%	
1.1.3	Чөлөөт бүсэд үйл ажиллагаа эрхэлж буй аж ахуйн нэгжийн хөрөнгө оруулалт, бүтээн байгуулалтын ажлыг эрчимжүүлэх;	Урсгал зардлаас	-Аж ахуйн нэгж, тоо -Хөрөнгө оруулалтын хэмжээ, мөнгөн дүн	Аж ахуйн нэгжийн тоо-17 Хөрөнгө оруулалтын хэмжээ-18,500,000,000.00 төгрөг	Аж ахуйн нэгжийн тоо -34 40,700,000,000.00 төгрөг	- Замын-Үүд чөлөөт бүсэд худалдаа, үйлчилгээний зориулалтаар 4 аж ахуй нэгж үйл ажиллагаа эхлүүлсэн. Дэд бүтцийн техникийн нөхцөл, архитектур төлөвлөлтийн даалгаврыг 14 аж ахуй нэгж батлуулан, 2025 оны 2-р улирлаас барилга, угсралтын ажлаа эхлүүлэхээр мэдэгдээд байна. - Хөрөнгө оруулалтын нийт хэмжээ 21.4 тэрбум төгрөг.	80%	
1.1.4	“Замын-Үүдийн дэд бүтцийг сайжруулах төсөл”-ийн хүрээнд хийгдсэн дэд бүтцийн 4 багц ажлын ашиглалт үйл ажиллагааг	Урсгал зардлаас	Санал хүргүүлж шийдвэрлүүлсэн эсэх (Тийм:1/Үгүй:0)	-	1	“Замын-Үүдийн дулааны станц” ТӨҮГ-ын даргатай дулаан хангамж, ус хангамж ариутгах татуургын ашиглалт үйл ажиллагааг жигдрүүлэх, тулгамдаж буй асуудлаар 2 удаагийн уулзалт зохион байгуулж, шаардлагатай засвар үйлчилгээг тухай бүр хийлгэн, хамтран ажиллаж байна. “Замын-Үүдийн дэд бүтцийн сайжруулах төсөл”-ийн хүрээнд хийгдсэн холбоо, сувагчлалын ажлын ашиглалт үйл ажиллагааг сайжруулах зорилгоор 2024 оны 03 сарын	40%	

	жигдрүүлэх талаар холбогдох байгууллагад санал хүргүүлж, шийдвэрлүүлэх;					22-ны өдөр “Юнивишн” ХХК-ийн инженер техникийн албан хаагчидтай чөлөөт бүсэд ажиллав. “Замын-Үүдийн дэд бүтцийг сайжруулах төсөл”-ийн хүрээнд хийгдсэн ус хангамжийн багц ажлын ашиглалт үйл ажиллагааг эрчимжүүлэх талаар 2024 оны 12 дугаар сарын 18-ны өдрийн Засгийн газрын хуралдаанаар хэлэлцүүлэхээр төлөвлөн ажиллаж байна.		
1.1.5	Чөлөөт бүсийн тухай хуулийн хэрэгжилтийн үр нөлөөний судалгаа хийж, сайжруулах санал боловсруулж, дээд шатны байгууллагад танилцуулах;	Урсгал зардлаас	Санал боловсруулж танилцуулсан эсэх (Тийм:1/ Үгүй:0)	-	1	- Чөлөөт бүсийн тухай хуулийн давхардал, зөрчлийг арилгах зорилгоор хууль тогтоомжийн хэрэгжилтэд дүн шинжилгээ хийх, гарч байгаа хүндрэл, бэрхшээл, нийгэмд үзүүлж байгаа эерэг, сөрөг нөлөөллийг илрүүлж, цаашид тухайн хууль тогтоомжийг зохистой үр дүнтэй хэрэгжүүлэх боломжит хувилбарыг тодорхойлох үүрэг бүхий ажлын хэсгийг Захирагчийн 2024 оны 03 дугаар сарын 01-ний өдрийн А/16 дугаар захирамжаар байгуулан, ажлын хэсэг тайлан, дүгнэлт, санал боловсруулан Эдийн засаг, хөгжлийн яаманд хүргүүлж ажиллав. - Монгол Улсын Ерөнхий сайдын 2024 оны 01 дүгээр албан даалгаврын 5.3-т заасан Замын-Үүд чөлөөт бүсийн хөгжлийн төлөвлөгөөг сайжруулж, бүтээн байгуулалтын ажлыг эрчимжүүлэх”, арга хэмжээний хүрээнд боловсруулах хууль тогтоомжийн төслийн жагсаалт, Засгийн газрын хуралдаанаар хэлэлцүүлэх хуваарийн санал боловсруулж, ШСАА-ны шинжээч Д.Нямжаргалд 2024 оны 10 дугаар сарын 23-ны өдөр и-мэйлээр хүргүүлсэн. - Монгол Улсын Их Хурлын 2024 оны намрын ээлжит чуулганы хуралдаанаар хэлэлцүүлэх хууль тогтоомжийн нэмэлт, өөрчлөлтийн санал боловсруулж, 2024 оны 08 дугаар сарын 12-ны өдрийн 01/166 дугаар албан бичгээр ШСАА-нд хүргүүлсэн.	80%	
1.1.6	Хөрөнгө оруулалтын гэрээг дүгнэх, шинэчлэх, хөрөнгө оруулагчдын мэдээллийн санг	Урсгал зардлаас	Гэрээ, тоо Гүйцэтгэл, хувиар	88 -	88	- Захирагчийн ажлын алба нь 2018-2022 оны хооронд иргэн, аж ахуйн нэгжүүдтэй хийсэн “Хөрөнгө оруулалтын гэрээ”-нд хяналт шинжилгээ, үнэлгээ хийж ажиллалаа. - Дүгнэсэн гэрээний тоо-73 “Замын-Үүд” чөлөөт бүсэд үйл ажиллагаа эрхлэх зөвшөөрөлтэй 81 аж ахуйн нэгжийн бүртгэлийн мэдээлэлд шинэчлэлт хийж, иргэн, аж ахуйн нэгжтэй цахим	72,9%	

	шинэчлэн боловсруулах;					системээр мэдээлэл солилцох, цахим мэдээллийн сан үүсгэх боломжийг бүрдүүлж ажилласан.		
1.2. Зэх зээл болон байгалийн нөөц баялагт ойр, ажиллах хүчний хангалттай нөөцтэй, аж үйлдвэрийг хөгжүүлэх тааламжтай орчин бүрдсэн бүс нутгийг сонгон хилийн дагуух эдийн засгийн хамтын ажиллагааны бүс байгуулах зорилт								
1.2.1	Монгол, Хятадын Замын-Үүд, Эрээний эдийн засгийн хамтын ажиллагааны бүс байгуулах тухай Монгол Улсын Засгийн газар, БНХАУ-ын Засгийн газар хоорондын хэлэлцээрийн хэрэгжилтийг эрчимжүүлэх;	Урсгал зардлаас	Хэрэгжилт, хувиар	10%	50%	“Монгол, Хятадын Замын-Үүд, Эрээний эдийн засгийн хамтын ажиллагааны бүс байгуулах тухай хэлэлцээр”-т тусгасан гурван түвшний удирдлагын механизм болох Хамтарсан гүйцэтгэх болон хамтарсан менежментийн зөвлөлийн Монгол талын бүрэлдэхүүнийг Гадаад харилцааны Сайдын А/51, А/74 дүгээр тушаалуудаар тус тус байгуулагдсан. 2024 оны 09 дүгээр сарын 11-ний өдөр Хамтарсан гүйцэтгэх зөвлөлийн Монгол талын шинэчилсэн бүрэлдэхүүний хурлыг зохион байгуулж, бүсийн бүтээн байгуулалтын ажлыг эрчимжүүлэх, үйл ажиллагаанд тулгамдаж буй асуудлыг хэлэлцэж, холбогдох байгууллагуудад чиглэл өгч ажиллав. 2024 оны 10 дугаар сарын 16-ны өдөр “Монгол, Хятадын Замын-Үүд, Эрээний эдийн засгийн хамтын ажиллагааны бүс”-ийн Хамтарсан гүйцэтгэх зөвлөлийн анхдугаар хуралдааныг БНХАУ-ын ӨМӨЗО-ы Хөх Хотод зохион байгуулж, талууд 5 асуудал дээр тохиролцоонд хүрч, протоколд гарын үсэг зурсан. Хэлэлцээрт заасны дагуу хамтарсан гүйцэтгэх зөвлөлийн хийж хэрэгжүүлсэн ажлын тайланг Хамтарсан зохицуулах зөвлөлд 2024 оны 12 дугаар сарын 06-ны өдрийн х/1364 дугаар албан бичгээр хүргүүлж, Засгийн газарт танилцуулах бэлтгэл ажлыг ханган ажиллаж байна. - Гадаад харилцааны сайдын 2024.11.22-ны А/75 тушаалаар Хамтын ажиллагааны бүсийн гол гарцын хил огтлон гарах цэгийн байршлыг тогтоох ажлын хэсэг байгуулагдаж, хилийн цэг дээр ажиллах товийг тохирох саналыг БНХАУ-ын талд ноот бичиг хүргүүлсэн.	70%	
1.2.2	“Замын-Үүд” чөлөөт бүсийн хөгжлийн ерөнхий төлөвлөгөөг БНХАУ-ын Эрээн	Урсгал зардлаас	Ерөнхий төлөвлөгөөний гүйцэтгэл, хувиар	10%	100%	“Замын-Үүд, Эрээний эдийн засгийн хамтын ажиллагааны бүсийн (Монгол тал) хөгжлийн ерөнхий төлөвлөгөөний хот байгуулалт болон эдийн засгийн төлөвлөлтийг БНХАУ-ын Зө жианы их сургуулийн Хот хөдөөгийн төлөвлөлт, төслийн судалгааны хүрээлэнгээр		

	хотын чөлөөт бүсийн ерөнхий төлөвлөгөөтэй уялдуулан боловсруулах ажлыг зохион байгуулах;					хийлгүүлэх саналтай байгааг уламжилж, үнийн санал авах тухай албан мэйлийг 2024 оны 05 дугаар сарын 15-ны өдөр илгээсэн. БНХАУ-ын 3ө Жианы их сургуулийн Хот хөдөөгийн төлөвлөлт, төслийн судалгааны хүрээлэнгээс 2024 оны 05 дугаар сарын 27-ны өдөр албан мэйлээр ирүүлсэн үнийн саналыг Азийн хөгжлийн банк, болон Сангийн яаманд танилцуулаад байна. • БНХАУ-ын ӨМӨЗО-ны Худалдааны танхимын 2024 оны 09 дүгээр сарын 30-ны өдрийн 725, 726 дугаар албан бичгүүдээр “Монгол, Хятадын Замын-үүд-Эрээний эдийн засгийн хамтын ажиллагааны бүсийг нийтлэг хөгжүүлэх ерөнхий төлөвлөгөөний анхны төсөл” болон “Хамтын ажиллагааны бүсийн (Хятад тал) хил дамнасан гол гарцын бүтээн байгуулалтын анхны төсөл”-д Шадар сайдын Ажлын албанаас Яам, агентлаг зэрэг нийт 25 байгууллага, “Хамтын ажиллагааны бүсийн (Хятад тал) хил дамнасан гол гарцын бүтээн байгуулалтын анхны төсөл”-д нийт 7 байгууллагаас санал авч, нэгтгэн боловсруулж Гадаад харилцааны яамаар дамжуулан Хятадын талд хүргүүлэв.	70%	
1.2.3	Азийн хөгжлийн банкны санхүүжилтээр хэрэгжиж буй “Эдийн засгийн хамтын ажиллагааны бүс хөгжүүлэх төсөл”-ийг удирдлага зохион байгуулалтаар хангах;	Урсгал зардлаас	Хэрэгжилт, хувиар	4%	20%	• “Эдийн засгийн хамтын ажиллагааны бүс хөгжүүлэх төсөл”-ийн хүрээнд: 1. Дэд бүтэц болон барилга байгууламж барьж ашиглалтад оруулах; 2. Тогтвортой менежмент, үйл ажиллагааг дэмжих; 3. Чөлөөт бүсэд нэвтрэх системийг байгуулах. гэсэн 3 бүрэлдэхүүн хэсгийг хэрэгжүүлэн ажиллаж байна. Үүнд: Бүрэлдэхүүн I-ийн хүрээнд: Эдийн засгийн хамтын ажиллагааны бүс хөгжүүлэх төслийн нарийвчилсан инженерийн зураг төсөл боловсруулах ажилд шаардлагатай дулаан хангамжийн техникийн нөхцөл болон Эдийн засгийн хамтын ажиллагааны бүс хөгжүүлэх төсөл хэрэгжүүлэх нэгжээс ирүүлсэн зураг төсөл боловсруулах зургийн даалгавруудыг хянаж, “Эдийн засгийн хамтын ажиллагааны бүс хөгжүүлэх төслийн хүрээнд баригдах “Замын-Үүд” чөлөөт бүсийн ачаа тээврийн гүний гарцын шалган нэвтрүүлэх нэг	43%	

2.1. Чөлөөт бүсийн дэд бүтцийн бүтээн байгуулалт, газрын харилцааны үйл ажиллагааг зохион байгуулах, хяналт тавих;

2.1.1	Чөлөөт бүсэд газар эзэмшиж буй иргэн, аж ахуйн нэгж талбарт газрын төлөв байдал, чанарын улсын хянан баталгааг хийлгэж, тайланг баталгаажуулах;	Урсгал зардлаас	Тайлан, тоо	-	61	- Газрын харилцааны цахим үйлчилгээнд газрын төлөв байдал, чанарын улсын хянан баталгааны тайлан хүлээн авах болон баталгаажуулах нэмэлт үйлчилгээ оруулах талаар албан хүсэлтийг Газар зохион байгуулалт, геодези, зураг зүйн ерөнхий газарт хүргүүлсэн. - Газар зохион байгуулалт, геодези, зураг зүйн ерөнхий газраас ирүүлсэн Газрын тухай хуулийн 18 дугаар зүйлийн 18.1.8-д “Газрын нэгдмэл сангийн удирдлагын нэгдсэн цахим системийн үйл ажиллагааны журмыг батлах” гэж заасныг үндэслэн журмын төсөлд 2024 оны 05 дугаар сарын 22-ны өдрийн 01/113 дугаартай албан бичгээр санал хүргүүлэв. - Чөлөөт бүсэд газар эзэмших эрхтэй 61 аж ахуйн нэгжид газрын төлөв байдал, чанарын улсын хянан баталгаа хийлгэх мэдэгдэх хуудсыг хүргүүлснээс 50 аж ахуй нэгж хийлгэсэн байна.	77%	
2.1.2	Чөлөөт бүсэд иргэн, аж ахуйн нэгжид болон төрийн байгууллагын зайлшгүй хэрэгцээнд газар олгох үйл ажиллагааг зохион байгуулах;	Урсгал зардлаас	Нэгж талбар, тоо	88	100	“Замын-Үүд” чөлөөт бүсийн Захирагчийн 2024 оны 01 дүгээр сарын 15-ны өдрийн А/05 дугаар захирамжаар батлагдсан 2024 оны газар зохион байгуулалтын төлөвлөгөөг хүргүүлж, төрийн болон төсөвт байгууллагын хэрэгцээнд олгох 2 нэгж талбарыг холбогдох журмын дагуу газрын удирдлагын нэгдсэн системд оруулж баталгаажуулав.	100%	
2.1.3	Чөлөөт бүсэд үйл ажиллагаа эрхэлж буй иргэн, аж ахуйн нэгжүүдэд Багануур, Зүүн өмнөд бүсийн цахилгаан түгээх сүлжээ ТӨХК-ний Замын-Үүд	Урсгал зардлаас	Техникийн нөхцөл, тоо	11	17	Чөлөөт бүсэд үйл ажиллагаа явуулж буй аж ахуйн нэгжийн хүсэлтийн дагуу цахилгаан трассын зургийг баталгаажуулж, “Чанг шэн олон улсын ачаа тээврийн чөлөөт бүс” ХХК, “Эко эм жи чөлөөт бүс” ХХК, “Ану-Интернэшнл чөлөөт бүс” ХХК /Үйлдвэрлэл/, “Ану-Интернэшнл чөлөөт бүс” ХХК /Худалдаа, үйлчилгээ/, “Жэй И Эйч чөлөөт бүс” ХХК, нийт 5 аж ахуй нэгжид гаргаж өгснөөр цахилгаан эрчим хүчээр хангагдсан.	100%	

	цахилгаан түгээх хэсэгтэй хамтран техникийн нөхцөл олгох;							
2.1.4	Худалдаа, бараа эргэлт болон мөнгөн урсгалын мэдээллийг сар бүрийн 25-ны дотор нэгтгэж, дээд шатны байгууллагад хүргүүлэх;	Урсгал зардлаас	Мэдээлэл, тоо		12	- Чөлөөт бүсэд үйл ажиллагаа явуулж буй нийт 9 аж ахуйн нэгжийн бараа эргэлтийн тайланг сар бүр боловсруулж, дээд шатны байгууллагад хүргүүлж ажиллав. - Чөлөөт бүсэд татваргүй барааны дэлгүүрийн үйл ажиллагаа эрхэлж байгаа аж ахуйн нэгжүүдийн борлуулалт 11 дүгээр сарын 30-ны өдрийн байдлаар нийт 601,743,10 ам доллар буюу 2,034,565,642.22 төгрөг байна.	100%	
2.1.5	Чөлөөт бүсийн “Бараа эргэлт, орох гарах урсгалд тогтмол хяналт тавьж, зөрчил гаргахгүй байх чиглэлээр арга хэмжээг авах, сар бүрийн 25-ны дотор тайлагнах;	Урсгал зардлаас	Тайлан, тоо		12	- Чөлөөт бүсэд үйл ажиллагаа явуулж буй аж ахуйн нэгжүүдийн бараа эргэлт болон чөлөөт бүс рүү зорчих хөдөлгөөнд хяналт тавих ажлыг Хилийн 0108 дугаар анги болон Замын-Үүд дэх Гаалийн газартай тогтмол хамтран гүйцэтгэж ажиллаж байна. 2024 оны 11 дүгээр сарын 31-ний өдрийн байдлаар чөлөөт бүсэд нэвтэрсэн 80892 зорчигч, авто тээврийн хэрэгслийн тоо 24662 байна.	100%	
Гурав. Хуулиар тусгайлан олгосон чиг үүргийг хэрэгжүүлэх зорилт, арга хэмжээ								
3.1.	Газрын төлбөрийн хураамжийн төлбөрийг төсөвт төвлөрүүлэх;	Урсгал зардлаас	Мөнгөн дүн	24,804,750.00 төгрөг	28,309,250.00 төгрөг	2024 оны 12 сарын 31-ний өдрийн байдлаар иргэн, аж ахуйн нэгжийн газрын жилийн төлбөрийн 41,834,75.00 төгрөг, төгрөгийг, аж ахуйн нэгжийн тусгай зөвшөөрөл, энгийн зөвшөөрлийн төлбөрийн 9,300,000.00 төгрөгийг 4 аж ахуйн нэгжийн чөлөөт бүсэд үйл ажиллагаа эрхлэх бүртгэлийн гэрчилгээнд өөрчлөлт оруулсан бүртгэлийн хураамжийн 118,000.00 төгрөгийг улсын төсөвт төвлөрүүлээд байна. “Замын-Үүд” чөлөөт бүс дэх “Татваргүй барааны дэлгүүр ажиллаж эхэлсэнтэй холбогдуулан авто замын байгууламж ашигласны төлбөр хураамжийг хурааж эхэлсэн бөгөөд 2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрийн байдлаар 24,662 авто тээврийн хэрэгсэл нэвтэрч, нийт 28,797,000.00 (хорин дөрвөн сая зургаан зуун жаран хоёр	100%	

						мянган) төгрөгийг Төрийн сангийн төсвийн нэмэлт санхүүжилтийн 100900009423 бүртгэлийн дансанд төвлөрүүлсэн.		
3.2.	Чөлөөт бүсэд согтууруулах ундаа худалдах, түүгээр үйлчилгээ эрхлэх, тамхи худалдах энгийн зөвшөөрөл, экспортлох зорилгоор уламжлалт технологиор үйлдвэрлэх согтууруулах ундаа үйлдвэрлэх тусгай зөвшөөрлийг олгох;	Урсгал зардлаас	Тусгай зөвшөөрөл, тоо	7	15	“Замын-Үүд” чөлөөт бүсийн Захирагчийн захирамжаар нийт 4 тусгай зөвшөөрөл, 3 энгийн зөвшөөрөл тус тус олгож, 2 тусгай болон 2 энгийн зөвшөөрлийн хугацааг сунгасан.	100%	
Дөрөв. Хуулиар олгосон нийтлэг чиг үүргийг хэрэгжүүлэх зорилт, арга хэмжээ								
4.1. Төрийн захиргааны болон хүний нөөцийн удирдлагын манлайллыг хангах, хууль эрх зүйн болон арга зүйн зөвлөгөө үзүүлэх зорилт, арга хэмжээ								
4.1.1	Төрийн захиргааны удирдлагын болон хүний нөөцийн удирдлагын манлайллыг хангах;	Урсгал зардлаас	Гүйцэтгэл, хувиар	-	100%	“Замын-Үүд” чөлөөт бүсийн Захирагчийн ажлын албаны 2024 оны гүйцэтгэлийн төлөвлөгөөг боловсруулан 2024 оны 01 дүгээр сарын 25-ны өдөр Монгол Улсын Шадар сайд бөгөөд Эдийн засаг, хөгжлийн сайдаар хянуулан баталгаажуулсан. - Хилийн цэргийн 0108 дугаар ангитай “Замын-Үүд, Эрээний эдийн засгийн хамтын ажиллагааны бүсийн харуул хамгаалалтын үйл ажиллагаанд 2024 онд мөрдөх түр журам” болон байгууллага хооронд 2024 онд “Харилцан ажиллах төлөвлөгөө” боловсруулан 2024 оны 03 дугаар сарын 22-ны өдрийн 01-А/20 дугаар захирамжаар баталгаажуулсан. - Замын-Үүд дэх хилийн мэргэжлийн 3, төрийн 1 нийт 4 байгууллагатай хамтран ажиллах гэрээ байгуулан ажиллав.	100%	

						- Замын-Үүд дэх Гаалийн газар, Хилийн 0108 дугаар ангид чөлөөт бүсэд үйл ажиллагаа явуулж буй иргэн, аж ахуй нэгжийн үйл ажиллагааг жигдрүүлэх талаарх мэдэгдлийг 2024.07.09-ний өдрийн 01/141, 01/142 дугаар албан бичгээр хүргүүлж үйл ажиллагааг эхлүүлсэн. - Удирдлагын академийн төрийн албаны сургуульд ахлах түшмэлийн 2, төрийн албаны дунд хугацааны мэргэшүүлэх 2, анх томилогдсон төрийн албан хаагчийн багц цагийн сургалтад 4, нийт 8 албан хаагчийг төрийн албаны мэргэшүүлэх багц сургалтад хамрууллаа. Мөн тус сургуулиас зохион байгуулсан “Удирдах арга барил” сэдэвт сургалтад 2 албан хаагч хамрагдав. - Төрийн албаны зөвлөлийн “7:4:10” сургалт, мэдээлэлд байгууллагын албан хаагчид тогтмол хамрагдсан. - Захирагчийн Ажлын албаны сургалт, мэдээллийн цагийн хуваарийн дагуу нийт 24 удаагийн сургалт зохион байгуулж албан хаагчдыг тогтмол хамруулж ажиллав. - БНХАУ-ын ӨМӨЗО-ны Хөх хотын Өвөр Монголын Хөдөө аж ахуйн их сургуульд 2024 оны 04 дүгээр сарын 23-ны өдрөөс 05 дугаар сарын 02-ны өдрийн хооронд зохион байгуулагдсан “Монголын хил дамнасан эдийн засгийн хамтын ажиллагааны бүтээн байгуулалтын сургалт”-д 2 албан хаагч хамрагдсан. - Монгол бичгийн үндэсний хөтөлбөрийг хэрэгжүүлэх ажлын хүрээнд албан хаагчдын дунд монгол бичгийн сургалтыг зохион байгуулж байна. - Төрийн албаны зөвлөлд төрийн жинхэнэ албаны сул орон тоог нөхөх тусгай шалгалтын сонгон шалгаруулалт зохион байгуулах хүсэлт, холбогдох материалыг бэлтгэн 2024.07.29-ний өдрийн 01/154, 2024.11.28-ны өдрийн 01/360 дугаар албан бичгээр тус тус хүргүүлж, хуулийн хүрээнд 2024 оны 12 дугаар сарын 10-ны өдрөөс Төрийн албан хаагчийг шилжүүлэн, сэлгэн ажиллуулах зарыг Төрийн албаны зөвлөлийн болон байгууллагын веб сайтад байршууллаа.		
4.1.2	“Замын-Үүд” чөлөөт бүсийн ажилтан, албан	Урсгал зардлаас	Хэрэгжилт, хувиар	-	100%	Ажилтан, албан хаагчдын нийгмийн баталгааг хангах хөтөлбөрийн хүрээнд Захирагчийн ажлын албанаас 2024 онд хэрэгжүүлэх ажлын төлөвлөгөө, Мэргэшил, мэдлэгийг		

	хаагчдын нийгмийн баталгааг хангах арга хэмжээ авч хэрэгжүүлэх;					дээшлүүлэх 2024 оны ажлын төлөвлөгөө, Хөдөлмөрийн аюулгүй байдал эрүүл ахуйн зөвлөлийн 2024 оны ажлын төлөвлөгөөг тус тус боловсруулан Захирагчийн 2024 оны 03 дугаар сарын 28-ны өдрийн А/22 дугаар захирамжаар батлав. - Захирагчийн 2024 оны 01 дүгээр сарын 31-ний өдрийн Б/07 дугаар захирамжаар өндөр насны тэтгэвэрт гарсан ахмадуудыг хүлээн авч, хүндэтгэл үзүүлэн 4 ахмадад найман зуун мянган төгрөгийн, 8 албан хаагчид таван сая нэг зуун мянган төгрөгийн нийт 5.900.000 төгрөгийн тэтгэмж олгов. - Албан хаагчдын ажлын үр дүнг харгалзан Монгол Улсын Шадар сайд бөгөөд эдийн засаг, хөгжлийн сайдын 2023 оны А/50 дугаар тушаал, Монгол Улсын Шадар Сайдын 2024 оны 62 дугаар тушаалыг үндэслэн давхардсан тоогоор төрийн үйлчилгээний 10 албан хаагчийн албан тушаалын цалингийн хэмжээг 40 хүртэл хувиар нэмэгдүүлэн тогтоолоо. - Төрийн албаны тухай хууль болон холбогдох хууль тогтоомжийн хүрээнд улирал бүр албан хаагчдын ажлын үр дүн, тайланг дүгнэн албан тушаалын цалингийн 50 хүртэлх хувийн мөнгөн урамшууллыг давхардсан тоогоор 52 албан хаагчдад 48,4 сая төгрөгийн, албан тушаалын цалинг 1,5 дахин нэмэгдүүлсэнтэй тэнцэх хэмжээний мөнгөн урамшууллыг 2 албан хаагчид тус тус олгосон. - Төрийн албан хаагчийн ёс зүйн тухай хууль, Монгол Улсын Ёс зүйн хорооны 2024 оны 02 дугаар сарын 19-ний өдрийн 05 дугаар тогтоолыг үндэслэн Захирагчийн 2024 оны 11 дүгээр сарын 15-ны өдрийн Б/58 дугаар захирамжаар 2 албан хаагчид урамшуулал олгосон.	100%	
4.1.3	Албан тушаалтны хувийн ашиг сонирхлын мэдүүлэг болон хөрөнгө орлогын мэдүүлгийг зохих журмын дагуу хугацаанд нь	Урсгал зардлаас	Хэрэгжилт, хувиар	-	100%	“Замын-Үүд” чөлөөт бүсийн Захирагчийн ажлын албанаас 2023 оны ХАСХОМ гаргах албан тушаалтны нэрсийн жагсаалтыг гарган, Эдийн засаг, хөгжлийн яамны хуулийн хэлтэст 2024 оны 01 дүгээр сарын 04-ний өдөр Захирагчийн 01/01 албан бичгээр хүргүүлсэн. - Авлигатай тэмцэх газраас зохион байгуулсан “Хувийн ашиг сонирхол хөрөнгө орлогын мэдүүлэг бөглөх, авлига ашиг сонирхлын зөрчлөөс ангид байх нь” сэдэвт	100%	

	гаргуулж, холбогдох тайлан мэдээг Авлигатай тэмцэх газарт хүргүүлэх;					сургалтад 2024 оны 02 дугаар сарын 02-ны өдөр нийт 12 албан хаагч хамрагдсан. - Захирагчийн ажлын албан хаагчдын 2023 оны хувийн ашиг сонирхлын болон хөрөнгө орлогын мэдүүлгийг гаргуулан баталгаажуулж, тайланг 2024 оны 02 дугаар сарын 23-ны өдөр Эдийн засаг, хөгжлийн яаманд хүргүүлсэн. - Захирагчийн ажлын албаны “Ашиг сонирхлын зөрчил, авлигаас урьдчилан сэргийлэх үйл ажиллагааны 2024 оны төлөвлөгөө”-г боловсруулж, Захирагчийн 2024 оны 03 дугаар сарын 28-ны өдрийн А/22 тоот захирамжаар баталсан.		
4.1.4	“Замын-Үүд” чөлөөт бүсийн Захирагчийн ажлын албаны үйл ажиллагаанд дотоод хяналт, шалгалтыг зохион байгуулах;	Урсгал зардлаас	Хэрэгжилт, хувиар	-	100%	Захирагчийн 2024 оны 03 дугаар сарын 28-ны өдрийн А/22 дугаар захирамжаар Дотоод хяналтыг хэрэгжүүлэх 2024 оны төлөвлөгөөг баталж, байгууллагын 2024 оны жилийн эцсийн тайланд хяналт, шинжилгээ- үнэлгээ хийж ажиллав.	90%	
4.1.5	Архив, албан хэрэг хөтлөлтийн тухай хууль болон түүнд нийцүүлэн гаргасан дүрэм, журмыг хэрэгжүүлэх;	Урсгал зардлаас	Хэрэгжилт, хувиар	-	100%	- Захирагчийн 2024 оны 01 дүгээр сарын 09-ний өдрийн А/02 дугаар захирамжаар хөтлөх хэргийн нэрийн жагсаалтыг батлуулан хэрэгжилтийг ханган ажилласан. - Захирагчийн 2023 оны А/17 захирамжаар Баримт нягтлан шалгах комиссыг байгуулж, 2024 оны 03 дугаар сарын 28-ны өдөр хуралдаж, архивын материалыг эрэмбэлэх, нягтлан шалгах үйл ажиллагааг зохион байгууллаа. 2024 оны 01 сарын 01-ээс 12 сарын 02-ны байдлаар нийт 227ш албан бичиг ирж, 367ш албан бичгийг төрийн болон хувийн хэвшил, иргэнд хүргүүлсэн байна. - Байгууллагын үйл ажиллагаатай холбоотой А захирамж 65ш, хүний нөөцтэй холбоотой Б захирамж 64ш гаргасан байна.	100%	
4.1.6	Иргэдээс төрийн байгууллага, албан тушаалтанд гаргасан өргөдөл, гомдлыг	Урсгал зардлаас	Хэрэгжилт, хувиар	-	100%	Захирагчийн ажлын албанд 2024 оны жилийн эцсийн байдлаар албан хаагчдаас ажлаас чөлөөлөгдөх тухай 6 өргөдөл, чөлөө хүсэх тухай 6, ажилд орох хүсэлт гаргах тухай 14 өргөдөл ирснийг бүртгэж, удирдлагад	100%	

	шийдвэрлэх тухай хуулийн хэрэгжилтийг хангах;					танилцуулан Захирагчийн дугаар захирамжуудаар хуулийн хугацаанд тус тус шийдвэрлэсэн байна.		
4.1.7	Гүйцэтгэлийн төлөвлөгөөний биелэлт, хэрэгжилтийг сар бүрийн 25-ны дотор дээд шатны байгууллагад хүргүүлэх;	Урсгал зардлаас	Тайлан, тоо	-	12	“Замын-Үүд” чөлөөт бүсийн Захирагчийн ажлын албаны гүйцэтгэлийн төлөвлөгөөний 2024 оны сарын болон хагас жилийн гүйцэтгэлийн төлөвлөгөөний биелэлт, хэрэгжилтийг гарган Эдийн засаг, хөгжлийн яаманд, жилийн эцсийн гүйцэтгэлийн төлөвлөгөөний биелэлтийг Шадар сайдын Ажлын албанд тус тус хүргүүлэв.	100%	
4.2 Гадаад харилцаа хамтын ажиллагааг хөгжүүлэх, олон нийттэй харилцах ажлыг зохион байгуулах, үйл ажиллагааг сурталчлах, мэдээллийн технологи, мэдээллийн сүлжээ, санг хөгжүүлэх, найдвартай ажиллагааг хангах зорилт, арга хэмжээ								
4.2.1	“Эдийн засгийн хамтын ажиллагааны бүс”-ийн үйл ажиллагааг сурталчлах арга хэмжээг зохион байгуулах;	Урсгал зардлаас	Арга хэмжээ, тоо.	4	8	Эдийн засгийн хамтын ажиллагааны бүс сурталчлах ажлын хүрээнд 3 телевиз, 1 сонин, 5 сайттай хамтран ажиллав. Үүнд: - Зууны мэдээ сонины цахим хувилбар болох zms.mn сайтад “Замын-Үүд” чөлөөт бүсийг Олон улсын жишигт нийцүүлэн хөгжүүлнэ /2024.06.06/; - mongol.tur.mn сайтад “Замын-Үүд, Эрээний эдийн засгийн хамтын ажиллагааны бүс”-ийн хөрөнгө оруулалт; - ASU.mn, live tv, Mand.mn, montsame.mn, Tentsver.mn, Манд.мн сайтад “Замын-Үүд, Эрээний эдийн засгийн хамтын ажиллагааны бүс”-ийн Хамтарсан гүйцэтгэх зөвлөлийн Монгол талын шинэчилсэн бүрэлдэхүүний хурлын тухай мэдээлэл; - Mass-TV-д Бүсүүдийн хөгжлийн үндэсний чуулганы Говийн бүсийн Хамтын ажиллагаа салбар хэлэлцүүлгийн мэдээлэл; Дээрх мэдээллийг байгууллагын цахим хуудсууд болох zfh.gov.mn сайт, Замын-Үүд чөлөөт бүс /Zamiin-Uud free zone/ гэсэн фейсбүүк хаягуудад байршуулан түгээлт хийн ажиллалаа.	100%	
4.2.2	Олон улсын чөлөөт бүсүүдтэй холбоо харилцаа	Урсгал зардлаас	Арга хэмжээ, тоо.	4	8	БНХАУ-ын Худалдааны яамны дэргэдэх Олон Улсын бизнесийн академи /AIBO/, Бүгд Найрамдах Хятад Ард Улсын Шанхайн Жиао Тонг их сургууль, "Goodwe"		

	тогтоох, хамтын ажиллагааг өргөжүүлэх;		Чөлөөт бүсүүд, тоо			ухаалаг эрчим хүч санаачлагч компани, "Өвөр Монголын Олон Улсын худалдааны групп" ХХК, БНХАУ-ын "Kedacom" техник технологийн компани, Америкийн нэгдсэн Улсын элчин сайдын яам, Бээжингийн эдийн засаг, технологийн хөгжлийн бүс, Хятадын хөгжлийн хүрээлэн болон БНСУ-ын Инчоно чөлөөт бүсийн захиргаатай хамтран ажиллах талаар албан захидал илгээсэн бөгөөд Хятадын хөгжлийн хүрээлэнгээс хамтран ажиллах тухай санал ирүүлсэн. • БНХАУ-ын Сүжөөгийн чөлөөт худалдааны бүс, Шанхайн чөлөөт худалдааны бүс, Шямэний чөлөөт худалдааны бүсийн хөрөнгө оруулалтын талаар мэдээлэл бэлтгэж, Эдийн засаг, хөгжлийн яамны удирдлагуудад танилцуулав. • Лаос, БНХАУ, БНКУ, БНСУ-ын чөлөөт бүсүүдийн судалгаа хийж, дээд шатны байгууллагад танилцуулсан. • 2024 оны 10 дугаар сарын 28-ны өдөр зохион байгуулагдсан Монгол-Казахстаны хамтарсан бизнес зөвлөлийн анхдугаар хуралд Замын-Үүд, Эрээний Эдийн засгийн хамтын ажиллагааны бүсийн танилцуулгыг хийж, Бүгд Найрамдах Казахстан Улсын Хоргос чөлөөт бүстэй Хамтын ажиллагааны санамж бичгийг үзэглэв.	90%	
4.2.3	Хэвлэл мэдээлэл, олон нийттэй харилцах ажлыг зохион байгуулах, мэдээллийн технологийн аюулгүй байдлыг хангаж ажиллах;	Урсгал зардлаас	-Веб сайтын хандалт, тоо -Мэдээ, мэдээлэл тоо.	730000 50	1000000 100	• Байгууллагын цахим хуудсанд 2024 онд зочилсон хүний тоо 130602, хуудсанд нэвтэрч мэдээлэл хайж үзсэн хандалтын тоо 783298 байна. • Байгууллагын албан хаагчдын албаны цахим хаягийн аюулгүй байдлыг ханган ажиллаж байна. • “Замын-Үүд” чөлөөт бүсийн Захирагчийн Ажлын алба, БНХАУ-ын ӨМӨЗО-ны Эрээн хотын Ардын засгийн газартай хамтран БНХАУ-ын Бээжин хотод 2024 оны 05 дугаар сарын 31-ний өдөр “Замын-Үүд, Эрээний эдийн засгийн хамтын ажиллагааны бүс”-ийн хөрөнгө оруулалтын чуулга уулзалтыг зохион байгуулав. Тус чуулга уулзалтын үеэр 200 гаруй хөрөнгө оруулагчдад мэдээлэл хүргэж, 100 гаруй аж ахуйн нэгж, бизнес эрхлэгчдэд бүсийн танилцуулга материалыг тарааж, үйл ажиллагааны мэдээг бэлтгэн байршуулж түгээлт хийж ажиллалаа.	100%	

						Үүнд: • TV-5 телевизийн оройн 19 цагийн цаг хөтөлбөр /2024.06.05/ “Замын-Үүд, Эрээний эдийн засгийн хамтын ажиллагааны бүс”-ийн 200 гаруй төлөөлөл уулзлаа; • Зууны мэдээ сонины цахим хувилбар болох zms.mn сайтад “Замын-Үүд” чөлөөт бүсийг Олон улсын жишигт нийцүүлэн хөгжүүлнэ /2024.06.06/; • mongoltur.mn сайтад “Замын-Үүд, Эрээний эдийн засгийн хамтын ажиллагааны бүс”-ийн хөрөнгө оруулалтын чуулга уулзалт боллоо гэсэн гарчигтайгаар тус тус нийтлэгдэж олон нийтэд хүрч сурталчилгаа хийгдлээ. • Төрийн ордны нутгийн удирдлагын танхимд 2024 оны 09 дүгээр сарын 11-ний өдөр “Монгол, Хятадын Замын-Үүд, Эрээний эдийн засгийн хамтын ажиллагааны бүс байгуулах тухай Монгол Улсын Засгийн газар, БНХАУ-ын Засгийн газар хоорондын хэлэлцээр”-ийн хэрэгжилтийг хангах, эрчимжүүлэх чиглэлээр Хамтарсан гүйцэтгэх зөвлөлийн Монгол талын бүрэлдэхүүний хурлыг зохион байгуулав. “Замын-Үүд, Эрээний эдийн засгийн хамтын ажиллагааны бүс”-ийн Хамтарсан гүйцэтгэх зөвлөлийн Монгол талын шинэчилсэн бүрэлдэхүүний хурал боллоо гэсэн мэдээ ASU.mn, live tv, Mand.mn, montsame.mn, Tentsver.mn, Манд.мн гэсэн мэдээллийн сайтуудаар гарсан. • Бүсүүдийн хөгжлийн үндэсний чуулганы Говийн бүсийн Хамтын ажиллагаа салбар хэлэлцүүлэгт /2024.10.26/ “Замын-Үүд” чөлөөт бүсээс мэдээлэл өгч оролцсон. Mass TV-ээр шууд дамжуулалт хийгдсэн бөгөөд байгууллагын цахим хуудаснуудад түгээлт хийж ажиллалаа. • Бүгд Найрамдах Хятад Ард Улсын Худалдааны яам, Шанхай хотын Ардын Засгийн газар хамтран зохион байгуулдаг “Хятадын Олон Улсын Импортын Экспо” 2024 оны 11 сарын 5-10-ний өдрүүдэд БНХАУ-ын Шанхай хотноо 7 дахь	
--	--	--	--	--	--	--	--

						жилдээ зохион байгуулагдав. Тус арга хэмжээний салбар хуралдаанд Бүгд Найрамдах Хятад Ард Улсын Өвөр Монголын Өөртөө Засах орны Ардын Засгийн газартай хамтран “Замын-Үүд, Эрээний эдийн засгийн хамтын ажиллагааны бүс”-ийн дэд бүтэц, хууль эрх зүйн орчин, хөнгөлөлт чөлөөлөлт, өнөөгийн байдал, хэрэгжүүлж буй төсөл хөтөлбөрийг дотоод гадаадын 500 гаруй аж ахуйн нэгжүүдэд танилцуулж, мэдээлэл хүргэж ажиллалаа. Нийт давтагдсан тоогоор байгууллагын цахим хуудаснуудад 80 гаруй мэдээлэл оруулж олон түгээлт хийн олон нийтэд сурталчилсан байна.		
4.3 Чөлөөт бүсийн бүртгэл санхүү, төсвийн удирдлагыг хангах зорилт, арга хэмжээ								
4.3.1	Батлагдсан төсвийн санхүүжилтийг холбогдох хууль тогтоомжийн дагуу үр ашигтай зарцуулж, төсвийн гүйцэтгэлийн мэдээг шилэн дансанд байршуулж тайлагнах;	Урсгал зардлаас	Шилэн дансанд тайлагнасан тайлан мэдээ, тоо	Шилэн дансанд байршуулсан мэдээний тоо-157	Шилэн дансанд байршуулсан мэдээ, тайлангийн тоо-171	2024 онд үндсэн үйл ажиллагааны зардалд 1,503,030.4 сая төгрөг батлагдаж, мөн оны 9 дүгээр сард хийгдсэн төсвийн тодотголоор 1,469,545.7 сая төгрөг буюу 33,484,7 сая төгрөгөөр буурч төсөв батлагдсан. Үндсэн цалингийн зардал 30,694,7 сая төгрөгөөр буурч, дотоод албан томилолтын зардал 2,790.0 сая төгрөгөөр нэмэгдсэн. 2024 оны 12 дугаар сарын 05-ны байдлаар үндсэн үйл ажиллагааны зардалд 1,237,8 сая төгрөг, байр ашиглалтын үйлчилгээнд 68,2 сая төгрөг, ажил олгогчоос олгох тэтгэмж, урамшуулалд 5,9 сая төгрөгийн санхүүжилтийн эрх олгосноос, 953,8 сая төгрөг буюу 73,0 хувийн гүйцэтгэлтэй байна. - Нэмэлт санхүүжилтийн дансанд 11 дүгээр сарын 30-ны байдлаар тасалбар хураамжаас 24,2 сая төгрөгийг төвлөрүүлж, 17,799.0 төгрөгийн зарцуулах эрхийн хүсэлтийг Сангийн яаманд хүргүүлж багаж, техник хэрэгслийн зардалд 7,479.2 сая төгрөг, дотоод албан томилолтын зардалд 5,372.0 сая төгрөг, улсын мэдээллийн маягт хэвлэх, бэлтгэх зардалд 0,5 сая төгрөг, хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх зардалд 3,360.0 төгрөг, бусад нийтлэг ажил үйлчилгээний татвар хураамжийн зардалд 1,087.8 сая, нийт 17,299.5 сая	100%	

						төгрөгийн эрхийг тус нээлгүүлж, 15,794,5 сая төгрөгийг буюу 91.3%-ийг зарцуулаад байна. “Замын-Үүд” чөлөөт бүсийн Захирагчийн ажлын албаны www.zfz.gov.mn, “Шилэн данс”, Сангийн яамны https://info.shilendans.gov.mn/ сайтад тухайн жилийн төсөвт орсон нэмэлт, өөрчлөлт, төсвийн байгууллагын батлагдсан төсөв, гүйцэтгэл, хэтрэлт хэмнэлтийн шалтгаан, цалингийн гүйлгээнээс бусад 5 сая төгрөгөөс дээших үнийн дүн бүхий орлого, зарлагын гүйлгээнүүдийг сар бүр мэдээлж, 171 мэдээг хуулийн хугацаанд нь тайлагнаж, ил тодын тухай хуулийг хэрэгжүүлэн ажилласан.		
4.3.2	“Замын-Үүд” чөлөөт бүсийн Захирагчийн ажлын албаны 2025 оны төсвийн төсөл, 2026-2027 оны төсвийн төсөөллийг эцэслэн боловсруулж батлуулах, тайлан мэдээг сар бүрийн 25-ны дотор холбогдох дээд шатны байгууллагад хүргүүлж батлуулах;	Урсгал зардлаас	Батлагдсан төсөв, мөнгөн дүн.	2024 оны төсөв 1,503,030.40 төгрөг	2025 оны төсөв 2,250,000.00 төгрөг	“Замын-Үүд” чөлөөт бүсийн Захирагчийн ажлын албаны 2025 оны төсвийн төслийг 4,233,281.7 төгрөг, 2026 оны төсвийн төсөөллийг 5,027,379.7 төгрөг, 2027 оны төсөөллийг 6,096,307.2 төгрөг байхаар боловсруулан Захирагчийн 2024 оны 07 сарын 22 өдрийн 01/151 дугаар албан бичгээр Шадар сайдын ажлын албанд хүргүүлж ажиллав. - Мөн “Замын-Үүд” чөлөөт бүсийн Захирагчийн ажлын албаны 2024 оны төсвийн тодотголыг боловсруулан Шадар Сайдын ажлын албанд хүргүүлсэн. 2024 оны төсвийн тодотголоор 2,491,865.9 мянган төгрөгийн санал явуулсан ба 1,469,545.7 мянган төгрөг батлагдсан. 2024 оны батлагдсан төсөв 1,503,030.3 мянган төгрөг, үүнээс тодотголоор 36,274.70 мянган төгрөгийг үндсэн цалингаас "Цагааннуур" чөлөөт бүсэд шилжүүлсэн, мөн 2,790 мянган төгрөг нь дотоод томилолтод "Шинэ хөдөө" хөтөлбөрийн дагуу нэмэгдэж орсон.	100%	
4.3.3	Төсвийн хөрөнгөөр бараа, ажил үйлчилгээ худалдан авах болон хөрөнгийн ашиглалт, зарцуулалтын ил	9,400,000.00 төгрөг	Батлагдсан төсвийн зарцуулалт, хувиар. Шилэн данс, тоо	-	100%	2023 оны байгууллагын жилийн эцсийн санхүүгийн тайланг Эдийн засаг, хөгжлийн яамны санхүүгийн хэлтэст хуулийн хугацаанд хүргүүллээ. Мөн Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газрын https://umch.sgov.mn/ цахим системд 2023 оны үндсэн хөрөнгийн орлого, зарлагын хөдлөлийн тайлан, 2023 оны жилийн эцсийн санхүүгийн тайланг байршуулсан.	100%	

	тод байдлыг хангаж ажиллах;					Батлагдсан төсвийн гүйцэтгэл, хэмнэлт, хэтрэлтийн болон орлогын мэдээг сар бүрийн 31-ний өдрөөр тасалбар болгон Эдийн засаг, хөгжлийн яамны санхүүгийн хэлтэст хүргүүлж, мэдээг баталгаажуулан Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, бусад хууль тогтоомжийн хэрэгжилтийг ханган ажиллаж байна.		
4.3.4	Үндсэн хөрөнгө, бараа материалын тооллогыг хагас, бүтэн жилээр хийж үндсэн хөрөнгийн хөдөлгөөний тайланг холбогдох газруудад хүргүүлж, дүгнүүлэх;	Урсгал зардлаас	Тооллогын тайлан, дүгнэлт, тоо.	2	2	- Захирагчийн 2024 оны А/14 дугаар захирамжаар байгуулагдсан “Байгууллагын өмч хамгаалах байнгын зөвлөл”-ийн гишүүд 2024 оны 6 дугаар сарын 03-ны өдөр хуралдаж, үндсэн хөрөнгийн дансанд бүртгэлтэй, үлдэх өртөггүй, зарим эд хөрөнгийн ашиглалтын хугацаа сунгах, үнийг шинэчлэн тогтоох талаар хэлэлцэж тодорхой саналыг Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газарт хүргүүлж, шийдвэрлүүлэн ажиллалаа. - Захирагчийн 2024 оны А/53 дугаар захирамжаар үндсэн хөрөнгийн дансанд бүртгэлтэй 84 нэр төрлийн 116 ширхэг нийт 383,444,319.20 төгрөгийн балансын үнэ бүхий өртөгтэй эд хөрөнгийн ашиглах хугацааг 1 жилээр сунгаж, нийт өртгийг 76,688,863.84 төгрөгийн өртгөөр шинэчлэгдсэнийг үндсэн хөрөнгийн данс бүртгэлд тусган үндсэн хөрөнгийн хөдлөл өөрчлөлтийн тайланг ерөнхий нягтлан бодогчоор баталгаажуулан биелэлтийг Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газарт хүргүүлж ажиллалаа.	100%	
	Хэрэгжилтийн ерөнхий дүн (7 зорилтын хүрээнд 30 арга хэмжээ)					Нийт 30 ажил төлөвлөсөн жилийн эцсийн хэрэгжилтийг 87,9% биелэлттэй байна.	89,6%	89,6 %

---o0o---